

УДК 398.2

DOI: 10.22162/2587-6503-2020-3-15-174-188

«Луу унжих» домгийн аман сурвалжийн шинжилгээ (= Исследование устной версии легенды о «Луу унжих» (смерче))

Батмөнх Г. ¹

¹ Институт языка и литературы Академии наук Монголии (д. 54а, пр. Энхтайван, район Баянзурх, 13330 Улан-Батор, Монголия)
научный сотрудник
E-mail: batmunkh3377@gmail.com

© КалмНЦ РАН, 2020

© Батмунх Г., 2020

Аннотация. Автор в статье рассматривает явление природы, нашедшее отражение в устных преданиях, получившее название *луу унжих* («смерч»), на материале образцов монгольского фольклора, а также на основе анализа устных свидетельств очевидцев, наблюдавших это явление или слышавших о нем, дает научную оценку и уточняет терминологию. Если рассматривать природное явление, которое монголы называют *луу унжих* и передают в легендах, то его можно описать как «сильный вихрь, который появляется в кучево-дождевом облаке, прямо вертикальный к земной поверхности, иногда обходящий по кругу искривленную ось, образуя при этом вид воронкоподобной трубы».

Ключевые слова: *луу унжих*, легенда, устная версия, смерч, сильный вихрь, ветер

Благодарность. Материалы статьи апробированы на Международной научной онлайн-конференции «Монголоведение в начале XXI в.: современное состояние и перспективы развития – II», проведенной при финансовой поддержке РФФИ (проект № 20-09-22004) и частичной поддержке гранта Правительства РФ (№ 075-15-2019-1879).

Для цитирования: Батмөнх Г. «Луу унжих» домгийн аман сурвалжийн шинжилгээ (= Исследование устной версии легенды о «Луу унжих» (смерче)) // Бюллетень Калмыцкого научного центра РАН. 2020. № 3. С. 174–188. (На монг.) DOI: 10.22162/2587-6503-2020-3-15-174-188

UDC 398.2

DOI: 10.22162/2587-6503-2020-3-15-174-188

Analysis of the Oral Version of the Legend about «Luu Unzhikh» (tornado)

*Batmunkh G.*¹

¹Institute of Language and Literature of the Academy of Sciences of Mongolia (54a, Enkhtaivan ave., Bayanzurkh distr, Ulan Bator 13330, Mongolia)
Research Associate
E-mail: batmunkh3377@gmail.com

© KalmSC RAS, 2020

© Batmunkh G., 2020

Abstract. The author in his article analyzes of the natural phenomenon that is reflected in oral legends named *luu unzhikh* ('tornado') on the materials of Mongolian Folklore samples and on the basis of the analysis of oral testimonies of the people who witnessed or heard about it, gives a scientific evaluation and specifies terminology. When analyzing the natural phenomenon that Mongols call *luu unzhikh* and reflect in legends it can be described as 'a strong whirlwind that emerges in thundercloud, vertical to ground surface and sometimes detours irregular axis forming a vortex'.

Keywords: *luu unzhikh*, legend, oral version, tornado, whirlwind, wind

Acknowledgement. The article was presented at the international scientific online conference "Mongolian Studies at the beginning of the 21st century: Current State and Development Prospects – II", held with the financial support of RFBR (project № 20-09-22004) and partial support of the Russian Government Grant (№ 075-15-2019-1879).

For citation: Batmunkh G. Analysis of the Oral Version of the Legend about «Luu Unzhikh» (tornado). In: *Bulletin of the Kalmyk Scientific Center of the RAS*. 2020. No. 3. Pp. 174–188. (In Mong.) DOI: 10.22162/2587-6503-2020-3-15-174-188

Монголчууд лууг олон дүрд хувилдаг гэх буюу “*луу ерэн есөн дүрд хувилдаг, бурхан багш зуун дүрд хувилж чаддаг. Тийм учир бурхан багш л лууг жинхэнэ дүрээр нь олж харсан*” гэлцдэг билээ. Лууг мөн өвөл ичдэг амьтан хэмээнэ. Энэ тухай “*худагт ичдэг, хумсанд ичдэг, бууцанд ичдэг гэсэн хууч яриа бий. Худагт ичдэгийн учир луу усны амьтан болохоос учир тодорхой. Хумсанд ичдэг гэж үздэгээс зарим ихэс дээдэс хумсаа ургуулдаг байсан нь хэрэв ичвэл буян заяа тогтоож, луу мэт баян тарган амьдарна гэж үздэг байв. Бууцанд ичвэл тэр бууцанд нь цас тогтохгүй дорхноо хайлж, мал сүрэг тарган тавтай өвөлждөг*” хэмээн бичжээ [Арьяасүрэн, Нямбуу 1992: 733]. Мөн зарим нутагт өндөр хад асга, агуй хонгилд ичдэг гэх нь байна. “Луу ичих” домгийн тухайд бид өмнө аман сурвалж болоод археологийн дурсгалууд, бусад баримт материалыг ашиглан уг домгийг тодруулан сурвалжилж, судалгааны өгүүлэл, илтгэл хэлэлцүүлж байсан тул энэ удаад “луу унжих” домгийг сонгон авч тодруулахыг зорьлоо.

“Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутаг Цэций уулын зүүн хойд талд нь “Могойт” гэдэг ус худаг байдаг. Тэр ус олон жилийн түүхтэй дээр үеийн худаг учир хашлага нь хүртэл нов ногоон хөгцтэй болжээ. Энэ худагт эрт дээр үед нэгэн их **борооноор луу унжиж ороод** 3 хоног байсан бөгөөд гурав дахь өдөр нь дахин бороо говь даяар орж өн болсон бөгөөд тэр өдөр асар их дуу гарч нөгөө **ичсэн луу** гарсан юм гэдэг. Харин тэр худагт луу заларсан учир Цэций уулын могойноос жилийн жилд хашлагад нь байх болсон юм гэдэг. Уг могой тэр бүр үзэгдэхгүй бөгөөд хэрэв тэр усны хашлагад нь могой харагдах юм бол хур бороо заавал ордог гэж ярилцдаг. Тийнхүү могой байдаг учир “Могойт” гэж нэрлэх болжээ” хэмээсэн домог бий [Равдан 2012: 306]. Уг домогт бидний өмнө өгүүлсэн “худагт луу ичих”-ийн тухай өгүүлэхийн дээр нэгэн их борооноор “**луу унжиж**” орсон гэсэн нь сонирхолтой. Энд өгүүлэн буй луу унжих гэж чухам юу болохыг тодруулан үзвэл “*ер бусын хүчтэй аянга цахилгаан цахиж, их мөндөр, бороо орохыг “луу унжив”, “соёолон луу унжив” гэдэг байна [Дулам 2011: 51]. “Луу сүүлээ шарвахаар аянга гялсхийдэг, луу тэнгэрээс унахыг үзсэн гэж бүр XIII зууны үед монголчууд хэлэлцдэг*” байсан мэдээ ч бий [Сүхбаатар 2001: 139].

Бас зарим нутгийнхны ярьдгаар нэгэн төрлийн хуй салхийг хэлэх бөгөөд түүнээс сэргийлэх домын зүйлс ч байна. Энэ тухай Г. Гонгоржав гуайн тэмдэглэлд “*нүхтэй зүйл бүрийн жижиг чулууг оосорлон гэрийнхээ баруун хойд талын хананд голдуу зүүдэг заншил монголчуудын дунд элбэг дэлгэр уламжлагдан иржээ. Эртний хүмүүс оромж гэрээ “луу унжих” мэтийн гэнэтийн хүчтэй хуй салхи, шуурганаас хамгаалахын тулд сур дээс зэрэг тэнжээ оосроор даруулан тэн авахдаа үзүүрийг нь үхэр чулуу мэт том хад чулуунаас бэхэлдэг*” [Гонгоржав 2005] байснаас ийнхүү жижиг нүхтэй чулууг шүтэх болсон гэжээ. Эдгээрээс ажиглавал “*тэнгэр муухайрахыг “луу унжлаа” гэдэг*” болох нь харагдаж байна [Арьяасүрэн, Нямбуу 1992: 734].

“Эрийн сайн Хан харангуй” туульд:

*“Дээд хан хурмастаас
Хуй салхи гарч
Хур бороо ороод
Таван луугийн дуу
Орой дээр нь тачигнаад
Таван зуун ган сумаар
Тал бүрээс нь аянга цахилгаан
Буулгаж бут ниргэх гэхэд нь
Таван лууг тал гараараа шүүрэн авч
Хүзүү толгойг нь тас мушгиад
Өвдөг доороо дараад
Аянга цахилгаанаар бууж байсан
Таван зуу ган сумыг нь авч
Хуга хуга татаад суув гэнэ
Тэгээд үүл татарч тэнгэр чилгэрэв”* хэмээн өгүүлдэг
[Катуу 2011: 213].

Аман сурвалж, домгуудаас харвал “луу унжих” хэмээхийг бүхий л нутагт аль нэг хэмжээгээр хэлэлцдэг нь ажиглагдаж байна. Бас жирийн нэг хуй салхийг хэлдэггүй бололтой. Бид Төв, Булган, Хэнтий зэрэг аймгийн нутагт “луу унжих”-ыг харсан хүмүүсээс аман сурвалжийн мэдээ авав. Эдгээрээс үзэхэд:

- Хэрхэн унждаг: дээрээс доошоо эргэлдэж буугаад буцаад дээшилдэг

- Дүр байдлын хувьд: *тод цагаан, сагсгар сүүлтэй юм шиг, бөөрөнхий цагариг үүсгэж эргэлддэг*
- Ямар үед: *бороо орсны дараа, долоо хоног шахуу бороо орсны дараа*
- Хугацаа: *арван минут, арав хорин минут болсон*
- Сайн, муу: *ер нь муу л гэдэг, зуд болно*

Үүн дээр нэмэрлэвээс Говь-Алтай аймгийн Хөхморьт сумын нутаг дахь “Луут чулууг тэнгэрийн дуу, галын аюул ган зудаас хамгаалдаг гэж нутгийнхан бэлгэшинэн газар дэлхийгээ аргадан тахиж, шүтэж ирсэн гэдэг. Энэ чулууны ойролцоо мал муулах, хэл ам хийх, хэрүүл шуугиан тарихыг цээрлэдэг байна. Луу ороосон чулууг шүтэх үед мах идэж, архи уухгүй бөгөөд зөвхөн сүү өргөж, цагаан идээ будаагаар чимж юу санаж бодсон есөн хүслээ шивнэж хэлдэг” байна [Равдан 2012: 440].

“Дархадын далан худалч” хэмээн олонд алдаршсан Соёгор Эрдэнийн ярианд:

“Олон жилийн урьд юмдаг. Анд яваад юу ч алдаггүй. Өлсөж, ядарч байна гэж жигтэйхэн. Гэтэл дуутай ширүүн бороо ороод, тэнгэр цэлмэхээр харсан чинь Уран дөшийн орой дээр үүлэн дотроос, урт гэгчийн улаан юм унжиж байна. Гайхсаар очвол, хөөрхий нэг залуухан төлгөн луу, тоглож гүйж яваад халтиран, тэнгэрийн цоорхойгоор доош унжиж байгаа нь тэр асанж” хэмээсэн байдаг. Үүнд лууны насыг тодорхой заан, “залуухан, төлгөн луу” гэсэн нь сонирхолтой. Өөрөөр хэлбэл, өмнө өгүүлсэнчлэн дуутай, ширүүн борооноор тэнгэрээс луу унждаг хэмээсэнтэй тохирохын дээр тэр луу нь “төлгөн луу” учир тоглож гүйж яваад гэнэдэж “тэнгэрийн цоорхойгоор” унжсан болж таарч байна.

“Их өлсөж явсан болохоор, бушуухан махнаас нь хэсгийг огтолж автал, тэнгэрийн дуу ганц удаа тас буугаад явчлаа. Нэг мэдсэн би өнөөх хэсэг махаа атгаатай хэвээр хэвтэж байна. Түргэхэн чанаж, цадтал идлээ. Хөөрхий хан хурмастын юм болохоороо мах нь хүртэл давс, сонгинотой байх юм билээ. Тэгээд хэсэг зуур унтаад сэрж харвал, түрүүчийн миний анх огтолж авсан мах тэр хэвээрээ байна. Уул нь би дараа идэхээ бодож хэсэг мах үлдээсэн юм л даа. Тэгээд гэртээ хариад махныхаа тала-

ар хоол хийгээд үлдсэнийг нь өглөө босоод харахад авсан хэсэг нь нөхөөд л ургачихсан байсан. Тэр зунаа зунжин идээд байтал харин намар болж тэнгэрийн дуу зогсохоор харсан чинь мах маань байхгүй, хоосон арьсархуу юм хэвтэж байж билээ [Дархадын далан худалч 2011: 15] хэмээн түүнийг лууны махнаас тасалж авахад тэнгэр хилэгнэж ниргэсэн ба тасалж авсан лууны мах нь зун буюу тэнгэрийн дуутай үед бол ургаж, төлжөөд л байдаг. Харин намар тэнгэрийн дуу үгүй болж, луу тэнгэрт байрлахаа болих үед мах нь ч мөн хатаж арьсархуу юм болсон гэж сэтгэмжлэн өгүүлжээ.

Эдгээрээс ажиглавал монголчууд лууг тэнгэр болон лусад байрладаг хэмээхийн дээр ган, зуд, салхи шуурга зэрэг байгалийн элдэв эерэг, сөрөг үзэгдлийг луутай холбон тайлбарладаг нь харагдаж байна. “Луу худагт ичих” нь тухайн нутагт өн болохын дохио болдог бол “луу унжих” нь ган, зуд болохын илрэл байж болох бөгөөд лууг эрхэмлэн дээдэлбээс элдэв гай гамшгаас хол хөндий байна хэмээн ойлгодог байна.

Монголчуудын луу унжих хэмээн домоглон сэтгэдэг байгалийн үзэгдлийг чухам юу болохыг тодруулан үзвэл цаг уурчдын хэлэхээр “догшин хуй” гэх “борооны бөөн үүлэнд бий болдог, газрын гадаргад эгц босоо, хааяа тахирласан тэнхлэгийг тойрон эргэж байгаа юүлүүр маягийн хуйлраа үүсгэдэг хуй салхи”-г хэлдэг байна [Хангайсайхан 1991: 24–26]. **Зөвхөн дулааны улиралд ажиглагддаг бөгөөд хийн мандлын доод үе давхаргын хэт тогтворгүй төлөвөөс шалтгаалж үүсдэг үзэгдэл тул монголчуудын төсөөллөөр луу тэнгэрт байрлах үе нь тохирч байна.** Мөн дор өгүүлэх аман сурвалжийн мэдээ ч *бороо орсны хойно болсон, хуй босоод, улаан шороо тавьж байгаа юм шиг* гэх зэрэг нь үүнтэй нийцэж байна.

“тэнгэрээс нарийн цагаан юм бууж ирээл, тэгээд тэр нь нуурыг бүтэн тойрсон. Бүтэн тойрохдоо хуй босоод улаан шороо тавьж байгаа юм шиг тойроод тэгээд буцаад нуурынхаа урд талд байдаг уулаар дамнаад уулын дээрээс үүл рүү ингээд/ гараараа зангаж үзүүлэв/ орсон. Тухайн үед орой яг нар дөнгөж

жаргасны дараахан байсан. Долоо хоног шахуу бороо орцон байсан. Тэгээд яг цэлмэж байхад л үүлнээс буусан. Яг бууж ирж байхдаа цагаан, буцаад гарахдаа ч гэсэн цагаан. Тэгээд яг тэр юу тойрч байхдаа болохоор улаан шороо босож байгаа юм шиг. Тав, арван минут л болсон байх. “Цэгээн цагаан” нуурыг яг тойроод л дээшээ гарсан [Намнандоржийн Баасанжав].

“Манайх Дэлгэрхааны Ар улаан дэл гэдэг газар байсан, зун. Тэгсэн чинь л гэнэтхэн хойноосоо тэнгэр дуугараад л, юүхэв ээ шороо бужигнуулаад, салхи гэдэг чинь зүгээр л жигтэйхэн болоод л, тэгээд айхтар ширүүн бороо л шуураад өнгөрсөн. Мал хуй чинь бужигнаад л одоо зүгээр сарниад жигтэйхэн болсон. Тэгээд л айхтар тэнгэр дуугарлаа л гэсэн. Тэгсэн орой мордоод би баруун хажуугаас хонио нааш нь туугаад ирсэн чинь за ямарч байсан нэг дөрөв, таван зуун метр болов уу, за ямарч байсан нэг тав, зургаан зуун метр газар, газрыг нь хөрсөөр нь эргүүлээд хаячихсан. Тэгээд энэ чинь одоо юу болоод улаан шороо ингээд эргүүлчихвээ гээд, ирээд хэлсэн чинь аав л “э тэр тэгэлгүй яахав тэр их айхтар дуугарч, их салхилсан, тэнгэрч айхтар юу яасан юм байгаа юм. Луу унжих гэж тэгдэг юм” гэж. Тэгээд өөрөө мордоод, яваад, үзээд, ирсэн чинь луу унжсан, луу унжих гэж ингэдэг газрын хөрсийг хөрсөөр нь эргүүлчихдэг гэж [Адьяагийн Даваасүрэн].

“Догшин хуйн хуйлран эргэлдэх хөдөлгөөн нь үүлэн дотор эхэлж доошилсоор газрын гадаргад хүрнэ. Хэдэн арван метрээр хэмжигдэх голчтой энэ юүлүүрэн хуйлраа нь үүлнээс доошлон газрын гадаргад шүргэж үүлний хамт хэвтээ чиглэлд шилжин буцаж дээшээ хөөрнө. Ингэж явахдаа тааралдсан биет, ургамал, амьтныг сүйтгэх асар их хүчтэй. Догшин хуйн тийм их эвдлэн сүйтгэх хүч, бас зарим зүйлийг огт хөдөлгөлгүй орхидог гайхалтай нууц нь түүний бүтцийн онцлогтой холбоотой юм. Догшин хуй салхийг “хана”, “дотоод хөндий гэсэн” хоёр хэсэгтэй гэж гэж үзэж болно. Догшин хуйн хурд 50-100 м/сек, зарим тохиолдолд 330 м/сек-ээс давж байсан баримт бий. Догшин хуйн энэ хурд нь түүний ханын эргэлтийн хурд бөгөөд эвдлэн сүйтгэх хүч нь үүнд л байдаг” [Хангайсайхан 1991: 25] ажээ.

Цаг уурын толиос үзвэл: “Англи-tornado, Орос-ураган, Европд-тромб” [Нацагдорж 2014: 579] хэмээн нэрлэдэг байна. Манай оронд догшин хуй тохиолдох нь ховор бөгөөд хөдөө, гадаа харсан хүн байх боловч ном бичигт тоймтой тэмдэглэгдэн үлдсэн нь цөөн байна. Эдгээрээс тухайлбал: “1952 оны дөрөвдүгээр сард Ховд аймгийн Мөст сумын Хужиртын аманд ачаатай тэмээ хөтөлж явсан хүнтэй догшин хуйн төрлийн салхи тааралдаж тэмээний бурантгийг нь хэрчсэн мэт таслаад ачаатай тэмээг нь хийсгэн авч одсон мэдээ бий.

1974 оны долоодугаар сарын 21-нд Хэнтий аймгийн Батширээт сумын Цагаан усны бригадыг дайрч өнгөрсөн догшин хуй ихээхэн эвдлэн сүйтгэх хүчтэй байжээ. Энэ хуй уртаараа 130 км, өргөнөөрөө 175-230м газрыг хамарч, замдаа дайралдсан бүхнийг сүйтгэн, модыг байн байн эргүүлэг маягаар газарт зоож, Цагаан усны бригадын төвийн 18 гэр, байшинг хийсгэн, 50 орчим мал, 10 гаруй хүний амь нас сүйджээ. Бригадын төвд зогсож байсан ЗИЛ-130 маркийн автомашиныг бүрмөсөн эвдэж, их биеийг нь 80 гаруй метр, хөдөлгүүрийг нь 600 м хол шидсэнийг үзвэл уг догшин хуйн хүч ямар байсан нь тодорхой юм [Хангайсайхан 1991: 26].

“Цаг уур, орчны шинжилгээний газар”-ын эрдэмтэн судлаачид 2014 оны долоодугаар сарын 26-нд Архангай аймгийн Хашаат сумын нутагт “луу унжсаныг” тэмдэглэн авч салхины хурд, сүйтгэлийн хэмжээ зэргийг үндэслэн F4 зэрэглэлд хамаарах болыхыг тодорхойлон, баримт материалыг цуглуулсан нь **монголчууд “луу унжих”-ыг шинжлэх ухааны үүднээс судлан шинжилж эхэлсний** илрэл билээ.

Дээр өгүүлсэн догшин хуйг цаг уур судлалд салхины хурд, эвдлэн сүйтгэх хүч зэргээр нь “F1-F5 хэмээн ангилдаг” байна [Нацагдорж 2014: 579]. Мөн F0 гэж байдаг нь “нөөлөг салхи” бөгөөд “борооны бөөн /Cb/ үүлний хамар дор үүсэх хуйлрал, газрын гадарга дээр хэдэн арван метр талбайг эзэлж, үүлэнд хүртэл өндөрт гарч, хэдэн минутаас хэдэн 10 минут үргэлжилнэ. Нөөлөг нь хамгийн сул хүчтэй догшин хуй F0 болно” хэмээсэн байна [Нацагдорж 2014: 579].

Нэмэн өгүүлбэл Булган аймгийн Бүрэгхангай уулын домог нь: “Эрт урьд цагт тэнгэрээс нэг луу бууж ирж, ард олонд аймшигтай гай гамшиг тарьжээ. Үлэмж хүчтэй нэгэн баатар эр тэр луутай ноцолдож цусыг нь урсган, ясыг нь цувуулан сөнөөгөөд урагш нь шидчихсэн гэнэ. Шидэгдсэн луу хад чулуун овоо болж тогтсон нь Бүрэгхангай уул болсон гэх ба цус урсгасан газрыг нь Цуст, яс цувуулсан газрыг нь Яст гэх болсон гэнэ” [Равдан 2012: 346] хэмээн тэнгэрээс луу буун ирж ард олонд гай зовлон авч ирсэн талаар өгүүлдэг.

Бүрэг уулын нэрийн талаар хэд хэдэн санал байдгийн нэг нь эрдэмтэн О. Сүхбаатарын санал юм. Тэрээр “оройд нь үүл манан хөшиглөн бүрэг бараг харагддагаас бүдэг, бүрэг гэсэн утгаар нэрлэсэн байж болох талтай. Гэвч Бүрэгхангай уулын төвд хэлээр байгаа сангийн сударт энэ уулыг Брүг хангай (brug hang kas) гэж тэмдэглэсэн нь нэн шинэ баримт болж байна. Энэ Брүг гэсэн үг нь Луу гэсэн утгатай төвд үг болно. Монголчууд уул усаа шинжихдээ дөрвөн хүчтэн болоод бусад ан амьтантай адилтган тайлбарлаж ирсэн нь газар усны магтаал, газар шинжихүйн сударт тодорхой туссан байдаг.

Тэгвэл Бүрэг уулын оройд үүл манан хөшиглөсөн байдгаас луу байдаг гэсэн төсөөллөөр ч юм уу эсвэл лууны хэлбэртэй атиралдан сунаж тогтсон байц байдлаар нь ч юм уу, дөрвөн хүчтэний нэгээр бэлгэдэл болгон нэрлэсний аль нь ч байж болох юм. Монголчууд газар шинжихүйн ёсоор бол атираатай үргэлжилсэн уул нурууг лууны шинжтэй гэдэг. Өөр нэг сонин зүйл гэвэл энэ зууны эхээр бүтээсэн Гүн Дашдэмбэрэлийн нутгийн зураг бүхий газрын нэрийг төвд үсгээр үгчилж бичсэний дотор бидний ярьж буй Бүрэг уулыг Brug (луу) гэсэн төвд үсгээр бичжээ. “Гэсэрийн тууж”-д Брүг луу гэсэн нэр гардаг нь сүм хийдийн дээвэрт урласан нэг зүйл гөрөөсийг хэлсэн байдаг. Дүгнэвэл Бүрэгхангай уул нь “Луут хангай уул” гэсэн нэр” [Сүхбаатар 2001: 20, 21] юм гэж тайлбарлажээ. Дээр хэлсэнчлэн “brug” гэдэг нь төвд хэлний “луу” гэсэн үг болно. Мөн энэ тайлбар дээр өгүүлсэн домогтой тохирч байгаа зэргээс үзвэл “Бүрэгхангай”-н нэр нь “Луут хангай” гэсэн үг бөгөөд оройд нь үүл манан хөшиглөсөн байдаг учир тэнд луу оршдог гэсэн төсөөллөөс

эсвэл хэлбэр төрхөөс нь болж, мөн тэнгэрээс луу буусан гэсэн домгийн улбаанаас ийнхүү нэрлэсэн бололтой.

Энэ бүгдээс ажиглавал монголчуудын “луу унжих” хэмээн домоглон сэтгэдэг байгалийн үзэгдэл нь дан ганц “догшин хуй”-г хэлэх бус “нөөлөг салхи”, “догшин хуй”, аянга цахилгааны хамт бий болдог “хар салхи” зэргийг лууны тухай төсөөлөл ойлголтоор ерөнхийлөн нэрлэсэн хэрэг юм.

Эдгээрийг дүгнэвэл:

1. Монголчууд лууг тэнгэр болон лусад байрладаг хэмээхийн дээр ган, зуд, салхи шуурга зэрэг байгалийн элдэв эерэг, сөрөг үзэгдлийг лууны ивээл хишиг болоод догшрон хилэгнэсний үр гэж төсөөлдөг нь харагдаж байна.
2. “Луу худагт ичих” нь тухайн нутагт өн болохын дохио бол “луу унжих” нь ган, зуд болохын илрэл хэмээх бөгөөд лууг эрхэмлэн дээдэлбээс элдэв гай гамшгаас хол хөндий байна гэж ойлгодог байна.
3. Монголчуудын “луу унжих” хэмээн домоглон сэтгэдэг байгалийн үзэгдэл нь цаг уурын шинжлэх ухаанд бол “догшин хуй”, “нөөлөг салхи”, “хар салхи” зэрэг борооны бөөн үүлнээс бий болдог агаарын хуйлраа, хүчтэй салхи юм.

Ном зүй

- Арьяасүрэн, Нямбуу 1992 — *Арьяасүрэн Ч., Нямбуу Х.* Монгол ёс заншлын их тайлбар толь. Улаанбаатар, 1992. 927 х.
- Болдбаатар 2008 — *Болдбаатар Ю.* Монгол нутаг дахь эртний нүүдэлчдийн задын шүтлэг. Улаанбаатар, 2008.
- Гонгоржав 2005 — *Гонгоржав Г.* Монголчуудын чулууны өв соёл. Улаанбаатар, 2005.
- Дархадын далан худалч 2011 — Дархадын далан худалч, Улаанбаатар, 2011.
- Дулам 2011 — *Дулам С.* Монгол бэлгэдэл зүй, IV боть. Зүүд, зөн совингийн бэлгэдэл зүй, цагийн бэлгэдэл зүй. Улаанбаатар, 2011.
- Катуу 2011 — *Катуу Б.* Монгол урианхайн аман зохиол. Улаанбаатар, 2011.
- Нацагдорж 2014 — *Нацагдорж Л.* Цаг уурын нэр томъёоны Англи-Орос-Монгол толь, Улаанбаатар, 2014.

- Равдан 2012 — *Равдан Э., нар.* Монгол газар нутгийн нэрийн мянган домгийн чуулган, Улаанбаатар, 2012.
- Сүхбаатар 2001 — *Сүхбаатар О.* Монголын тахилгат уул усны сангийн судар оршвой. Улаанбаатар, 2001.
- Хангайсайхан 1991 — *Хангайсайхан Х.* Цаг уурын цагаан толгой. Улаанбаатар, 1991.

Аман эх сурвалж

1. Батбаярын Хонгорзул, Хэнтий аймгийн Норовлин сумын уугуул, 1994 онд төрсөн, нохой жилтэй, эмэгтэй, МУИС-н IV ангийн оюутан, 2015.2.11-нд МУИС-н хичээлийн II байранд тэмдэглэж авав.
2. Сайнбуянгийн Мижид, Увс аймгийн Хяргас сумын уугуул, 1993 онд төрсөн, эрэгтэй, МУИС-ийн IV ангийн оюутан, 2015.2.5-нд Антоон Мостаэрт монгол судлалын төвд тэмдэглэж авав.
3. Намнандоржийн Баасанжав, 1993 онд төрсөн, тахиа жилтэй, эрэгтэй, МУИС-н IV ангийн оюутан, 2015.1.24-нд Антоон Мостаэрт монгол судлалын төвд тэмдэглэж авав.
4. Эрдэнэбилэгийн Одончимэг, Булган аймгийн Дашинчилэн сумын уугуул, 1993 онд төрсөн, тахиа жилтэй, эмэгтэй, МУИС-ийн IV ангийн оюутан, 2015.2.16-нд МУИС-н III дотуур байранд тэмдэглэж авав.
5. Гомбын Бямбажав, 1918 оны морь жилтэй, эмэгтэй, 2017.3.1-нд Төв аймгийн Бүрэн сумын Өнжүүл багт тэмдэглэж авав.
6. Адьяагийн Даваасүрэн, 1936 онд төрсөн, хулгана жилтэй, эрэгтэй, 2016.9.5-нд Төв аймгийн нэгдсэн эмнэлэгт тэмдэглэж авав.
7. Г.Буянтогтох, 1952 онд Архангай аймгийн Чулуут суманд төрсөн, луу жилтэй, эрэгтэй, 2016.11.16-нд ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнд тэмдэглэж авав.

ХАВСРАЛТ

“Луу унжих” домгийн аман сурвалж:

1. *Миний мэдэхээр хоёр ч удаа болж байсан /Хэнтий аймгийн Норовлин сум/. Нэгийг нь бол зүгээр сонсож байсан. Нөгөөтхийг нь бол, 11онд /2011/ зун долоон сард болж байсан. Тэгээд би өөрөө харсан. Эхлээд манай сумаас зүүн хойно, тод, тэгээд тийм нэг сагсгар сүүлтэй юм унжиж байснаа, тэгээд л тодроод, тодроод л, тодроод л, мэдэхгүй ээ арав хорин минут ойролцоогоор болсон*

байх аа тэр. Тэгээд хорин минут хэртэй үргэлжлээд эхлээд лууны сүүл гээд нэг цагаан юм унжиж байснаа сагсгар болоод тэгээд бүүр ийм бөөрөнхий цагариг болоод, тэгж байснаа цаашаа ингээд эргэлдээд, эргэлдээд алга болсон. Дээрээс доошоо нэг юм унжаад л ингээд/гараараа дүрслэн үзүүлэв/. Тэгээд уулын яг оройны тэнд, нэлээн том, дээшээ ингээд эргэлдээд л алга болсон. “Луу унжих”-ыг ер нь муу л гэдэг. Зуд муд, байгалийн ямар нэг муу үзэгдлийн дохио өгч байгаа гэдэг.

Батбаярын Хонгорзул, Хэнтий аймгийн Норовлин сумын
уугуул,
1994.4.20-нд төрсөн, эмэгтэй, нохой жилтэй, МУИС-н IV
ангийн оюутан,
2015.2.11-нд МУИС-н хичээлийн II байранд тэмдэглэж
авав.

2. Манай нутагт уул, хаданд уур манангаас болж хөлдсөн зүйлийг лууны хөөс гэдэг. Түүгээр толгойгоо угаавал үс өнгө зүс сайтай сайхан болдог гэдэг.

Сайнбуянгийн Мижид, Увс аймгийн Хяргас сумын уугуул,
1993.4.30-нд төрсөн, эрэгтэй, тахиа жилтэй, МУИС-ийн IV
ангийн оюутан,
2015.2.5-нд Антоон Мостаэрт монгол судлалын төвд
тэмдэглэж авав.

3. 2008 онд Төв аймгийн Лун сумын ойролцоо, төвөөс нааш 8 км зайд болсон. “Цэгээн цагаан” гэж нууранд луу буусан. Би яг тэр луу эсэхийг сайн мэдэхгүй л дээ. Хүмүүсийн яриагаар бол луу гэж ярьсан. Тэр үед тэнгэрээс нарийн цагаан юм бууж ирээд л, тэгээд тэр нь нуурыг бүтэн тойрсон. Бүтэн тойрохдоо хуй босоод улаан шороо тавьж байгаа юм шиг тойроод тэгээд буцаад нуурынхаа урд талд байдаг уулаар дамнаад уулын дээрээс үүл рүү ингээд орсон. Тухайн үед орой яг нар дөнгөж жаргасны дараахан байсан. Долоо хоног шахуу бороо орцон байсан. Тэгээд яг цэлмэж байхад л үүлнээс буусан. Яг бууж ирж байхдаа цагаан, буцаад гарахдаа ч гэсэн цагаан. Тэгээд яг тэр юу тойрч байхдаа болохоор улаан шороо босож байгаа юм шиг. Тав, арван минут л болсон байх.

“Цэгээн цагаан” нуурыг яг тойроод л дээшээ гарсан.

Намнандоржийн Баасанжав, 1993 онд төрсөн, тахиа жилтэй,
эрэгтэй, МУИС-н IV ангийн оюутан, 2015.1.24-нд
Антоон Мостаэрт монгол судлалын төвд тэмдэглэж авав.

4. Булган аймгийн Дашинчилэн суманд 2014 оны 7-р сарын 28-нд бороо орсны дараа үүлнээс нэг юм унжсан. Хүмүүс луу унжлаа гэж ярьсан. Тэнд байсан байшингийн суур нь л үлдсэн байсан. Хэр хугацаатай үргэлжилснийг мэдэхгүй би харчихаад буцаад орчихсон. Нэг тийм гозойсон цагаан, хуйларсан юм л байсан.

Эрдэнэбилэгийн Одончимэг, Булган аймгийн Дашинчилэн
сумын уугуул,
1993-нд төрсөн, эмэгтэй, МУИС-ийн IV ангийн оюутан,
2015.2.16-нд
МУИС-н III дотуур байранд тэмдэглэж авав.

5. Урьд луу унжих гэж нэг, урьд байсан юм. Унжиж байсан юм. Манайхны энүүхэн баруун хойно. Энэ Дөрөлжид байхад унжиж байсан юм. Намайг л ер нь жаахан байхад. Арван хэдтэй байхад юм болов уу. Тэр нь одоо дал ная, ная ерэн жил болж байгаа байх. Тэр нэг бөөн үүлнээс ингэж/гараараа дүрсэлж үзүүлэв/ нэг юм унжаад тэгээд ингээд махиганаад, дээшээ доошоо ингээд л яваад, дээшээ нэг агшаад тэгээд байсан. Газардвал сүйдэлчихдэг, салхи тавиад сүйдэлдэг гэж байсан. Дээшээ агшаад явал гайгүй гэж байсан. Тэгээд манайхан тэрүүнийг, дээшээ л агшиж байсан, манайхан тэгээд яахав Алтангэрэлээрээ дохиод, салхи тавина гээд айгаад л, тэгж байсан юм аа. Тэгээд дээшээ л агшичихсан тэгээд салхи тавиагүй. Доошоо л газардвал сүйдэлдэг юм л гэж ярьж байсан. Нэг тийм л юм байсан.

Гомбын Бямбажав, 1918 оны морь жилтэй, эмэгтэй,
2017.3.1-нд
Төв аймгийн Бүрэн сумын Өнжүүл багт тэмдэглэж авав.

6. Манайх Дэлгэрхааны Ар улаан дэл гэдэг газар байсан, зун. Тэгсэн чинь л гэнэтхэн хойноосоо тэнгэр дуугараад л, юүхэв ээ шороо буужигнуулаад, салхи гэдэг чинь зүгээр л жигтэйхэн болоод

л, тэгээд айхтар ширүүн бороо л шуураад өнгөрсөн. Мал хуй чинь бужигнаад л, одоо зүгээр сарниад жигтэйхэн болсон. Тэгээд л айхтар тэнгэр дуугарлаа л гэсэн. Тэгсэн орой мордоод би баруун хажуугаас хонио нааш нь туугаад ирсэн чинь за ямарч байсан нэг дөрөв, таван зуун метр болов уу, за ямарч байсан нэг тав, зургаан зуун метр газар, газрыг нь хөрсөөр нь эргүүлээд хаячихсан. Тэгээд энэ чинь одоо юу болоод улаан шороо ингээд эргүүлчхэв ээ гээд, ирээд хэлсэн чинь аав л “ээ тэр тэгэлгүй яахав тэр их айхтар дуугарч, их салхилсан, тэнгэрч айхтар юу яасан юм байгаа юм. Луу унжих гэж тэгдэг юм” гэж. Тэгээд өөрөө мордоод, яваад, үзээд, ирсэн чинь луу унжсан, луу унжих гэж ингэдэг газрын хөрсийг хөрсөөр нь эргүүлчихдэг гэж.

Би арван зургаа долоотой л байсан. Тэгэхэд нэг тэгж луу унжих гэдгийг, их салхи гараад, шороо бужигнуулаад, тэнгэр дуугараад, бороо ороод хавсруулаад л хаячхаж байсан юм. Зун л юм даг. Тэгж байсан юм. Тэрүүнийг би тэгж нэг үзсэн юм. Тэрий чинь ч би унжиж байгааг нь би ч юуг нь харах вэ дээ гэр лүү л дайраад л, гэрт л амь хоргодож л байсан. Үгүй ээ тэр мөн айхтар, тэнгэр тачигнаад л, дуугараад зүгээр юүхэв, тэгж л байсан юм даа.

Адьяагийн Даваасүрэн, 1936 онд төрсөн,
хулгана жилтэй, эрэгтэй,
2016.9.5-нд Төв аймгийн нэгдсэн эмнэлэгт тэмдэглэж авав.

7. Энийг ярьсан хүн бол Батбуян гэж хүн байсан юм. Батбуян бол Архангай аймгийн Чулуут, Өндөр-Улааны нийлсэн, тийм хуучин Шиваа Шивээтийншавь гэж, Шивээт гүний шавь юм. Сум хуваагдахад Өндөр-Улаанд хуваагдсан хүн байсан. Энэ хүн 36 онд цэрэгт явсан байна. 1936 онд. Тэгээд хил дээр очоод, хилийн цэрэг байж байгаад тэгээд харсан чинь Өвөр монголд одоо ингээд шашин ном нь хэвээрээ, овоо мовоо тахиад л их сайхан байж гэнэ ээ. Манайх байхгүй устгачихсан. Тэгэхээр мань эр чинь одоо маанит газар эрх, манзат газар аяга байж мэднэ гээд манаагаа орхиод явчихсан байгаа юм. Тэгээд цаашаа явчихгүй юу. Тэгээд яваад ороод, мань эр чинь Өвөр монголд байгаад бүүр авгай хүүхэдтэй болоод, Японы армийн бараг хурандаа мурандаа болсон юм уу даа. Тэгээд Япончуудтай нийлж Хятадуудыг Өвөр

монголоос хөөж гаргасан гэж ярьдаг байсан байхгүй юу. Тэгээд тэр хүн тэгж явж байх хоорондоо Өвөр монголд “луу унасан” байхыг харж гэнэ ээ. Нэг өдөр луу унасан мунасан бөөн юм болоод очсон чинь сүүдэр босгочихсон, сүүдэр дотор нэг ийм ботго шиг ийм бөхтэй бөгтгөр юм байна гэнэ. Тэгээд Өвөр монголын лам нар цуглаад одоо ном уншина, дээш нь гаргана барина гээд л тэр хооронд улсууд ус мусаар цацаад л норгоод байна гэнэ нөгөөхийг чинь. Тэгээд л лам нар нь ирлээ, номоо унших боллоо гээд дөрвөн лам ч юм уу, одоо цуглаад л ном уншиж эхэлсэн гэнэ ээ. Тэгтэл шороо хийсгээд л босоод, тэгж байснаа үүл хуралдаад л, тэгээд тэр үүл рүү л нөгөөх чинь гараад явчихсан гэж байгаа юм. Тэгээд яваад өгсөн. Тэгж би луу уначихсан байхыг нүдээрээ үзсэн гэж надад ярьдаг байхгүй юу. Би худлаа битгий яриад бай тийм юм хэзээ байдаг юм гэхээр энэ хоёр нүдээрээ харсаан гээд. Тэгээд надад төсөөлж өг гэсэн чинь ингээд байсан ийм бөгтөр ботго шиг жижгэвтэр юм байсан гээд.

70 онд /1970/ юм байна яг. Би тэгэхэд Архангайн багшийн сургуулийн сурагч байсан. Төгсөх гэж байсан. Хоёрдугаар анги төгсөх гэж байсан байна. Тэгэхэд мань эр надад яриад би тэгэхэд нь Маркс, Лениний хүмүүжилтэй ёстой битгий худлаа яриад бай, луу муу гэж ямар юм байдаг юм гэсэн чинь мань эр надад баталж ярьж байгаа байхгүй юу.

Г. Буянтогтох, 1952 онд Архангай аймгийн
Чулуут суманд төрсөн, луу жилтэй,
эрэгтэй, 2016.11.16-нд ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнд
тэмдэглэж авав.